



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, уг хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2000 оны 19 тоот тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг гаргаж, санал дүгнэлт боловсруулан 2014 оны 01 дүгээр сард багтаан Байнгын хороонд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Батчимэг Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Л.Цог Улсын Их Хурлын гишүүн
Сү.Батболд Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Энхсайхан Гадаад харилцааны яамны тусгай үүрэг гүйцэтгэгч
Элчин сайд

Г.Ганболд Гадаад харилцааны яамны Олон улсын
байгууллагын газрын захирал

А.Төмөр Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын
захирлын үүрэг гүйцэтгэгч

Н.Тэгшбаяр Цөмийн энергийн газрын дарга

А.Энхболд Татварын ерөнхий газрын дэд дарга

С.Заяадэлгэр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын
хорооны ажлын албаны зөвлөх

П.Туяа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын
хорооны ажлын албаны референт

3.Тэлмүүн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын
албаны шинжээч

Х.Майцэцэг Байгал орчин, ногоон хөгжлийн яамны ахлах
мэргэжилтэн

Н.Энхбаатар	Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
Г.Энхболд	Батлан хамгаалах яамны хуулийн зөвлөх
Б.Баатарцогт	Уул уурхайн яамны хэлтсийн дарга
Ч.Энхээ	Гаалийн ерөнхий газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Г.Энхтайван	Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн
А.Жаргал	Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн
Д.Түвшинцэнгэл	Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн шалган нэвтрүүлэх албаны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Биндэръяа	Цөмийн энергийн газрын Хуулийн хэлтэс ахлах мэргэжилтэн
Э.Батбаяр	Онцгой байдлын ерөнхий газрын гамшгаас хамгаалах газрын Шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Баярсайхан	Тагнуулын ерөнхий газрын ажилтан
Т.Лхагвадорж	Цагдаагийн ерөнхий газрын Нийгмийн хэв журам хамгаалах газрын Төлөвлөлт, зохицуулалтын хэлтсийн ахлах байцаагч
Д.Нандинжаргал	Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын 5 дугаар хэлтсийн ахлах төлөөлөгч
Ү.Сүхбаатар	Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн захирал

Нарийн бичгийн дарга:

Ц.Навчаа	Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын гуравдугаар нарийн бичгийн дарга
----------	---------------------------------------------------------------------------------

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГИЙН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


**Дэд хорооны даргын үүрэгт ажлаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн Гончигдоржийг өөрийн хүсэлтээр нь Тусгай хяналтын дэд хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 03


Улаанбаатар хот

Дэд хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

- 1.Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүүг сонгосугай.
- 2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлж, санал дүгнэлт гарган Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Дэмбэрэл Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Р.Амаржаргал Улсын Их Хурлын гишүүн
Сү.Батболд Улсын Их Хурлын гишүүн
Г.Батхүү Улсын Их Хурлын гишүүн
Б.Болор Улсын Их Хурлын гишүүн
Л.Цог Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсугай:

Ч.Сосорбарам Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх
Ж.Энхсайхан Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд
Ц.Батбаяр Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлт, судалгааны газрын захирал
Б.Чулуунхүү Гадаад харилцааны яамны Америк, Африкийн газрын захирал
Н.Наранбат Гадаад харилцааны яамны Европ, Ойрхи Дорнодын газрын захирал
Ч.Баярмөнх Гадаад харилцааны яамны Ази, Номхон далайн орнуудын газрын захирал
Т.Төгсбилгүүн Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал
Ш.Хишигсүрэн Гадаад харилцааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал
Ж.Чойнхор Ахмад дипломатч
Д.Идэвхтэн Монгол Улсаас ОХУ-д сууж байсан Элчин сайд

Г.Батсүх
П.Туяа

Ж.Лхамрагчаа


Ц.Батзаяа

Монгол Улсаас БНХАУ-д сууж байсан Элчин сайд
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
Ажлын албаны референт
УИХ-ын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн
Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих албаны референт
Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлт,
судалгааны газрын атташе, ажлын дэд хэсгийн нарийн
бичгийн дарга

3.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.


4.Санал, дүгнэлтээ 2014 оны 10 дугаар сард багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР

БАТЛАВ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2014 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Ажлын хэсгийн зорилго:

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлж, санал дүгнэлт гаргах

Ажлын хэсгийн ажиллах чиглэл:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлал, гадаад харилцааны салбарын бодлогын бусад баримт бичгийн хэрэгжилттэй танилцах, дүгнэх, санал боловсруулах;
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалтай гадаад харилцааны салбарын бодлогын бусад баримт бичгийн өөр хоорондын уялдаа холбоог үнэлэх, санал дүгнэлт гаргах;
3. Гадаад харилцааны салбарын бодлогын хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замын талаар санал дүгнэлт гаргах;
4. Гадаад харилцааны салбарын бодлогын баримт бичигт тусгагдсан бодлого, түүнийг хэрэгжүүлж байгаа талаар шаардлагатай тохиолдолд Монгол Улсаас гадаад улсад суугаа холбогдох Элчин сайд нарын мэдээллийг сонсох;
5. Ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт, Байнгын хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулан Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

-- оОо --



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаад бодлогын асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагааг /механизмыг/ боловсронгуй болгох, хариуцлагажуулах байдалд дүгнэлт хийж, санал дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Батчимэг Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

О.Баасанхүү Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганбат Улсын Их Хурлын гишүүн
Н.Номтойбаяр Улсын Их Хурлын гишүүн
С.Оюун Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон Улсын Их Хурлын гишүүн
Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсугай:

Ч.Сосорбарам Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны Ажлын албаны ахлах зөвлөх
Х.Бэхбат Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд
Ж.Энхсайхан Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд
Л.Галбадрах Гадаад харилцааны яамны Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд
Ц.Батбаяр Гадаад харилцааны яамны Бодлого төлөвлөлт, судалгааны газрын захирал
Г.Ганболд Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын захирал
Ш.Хишигсүрэн Гадаад харилцааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал
А.Төмөр Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын захирал
С.Сүхболд Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал

О.Машбат
П.Туяа

Гадаад харилцааны сайдын зөвлөх
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
Ажлын албаны референт


Б.Чинүүхэй

Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын зөвлөх, ажлын дэд хэсгийн нарийн
бичгийн дарга

3.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.


4.Санал, дүгнэлтээ 2014 оны 6 дугаар сард багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР

БАТЛАВ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2014 оны 04 дүгээр
сарын 22 ны өдөр

Улаанбаатар
хот

Ажлын хэсгийн зорилго:

Гадаад бодлогын асуудлаар шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох, хариуцлагажуулах байдалд дүгнэлт хийж, санал дүгнэлт гаргах

Ажлын хэсгийн ажиллах чиглэл:

1. Гадаад бодлогын асуудлаар шийдвэр гаргах өнөөгийн үйл ажиллагааг судлан дүгнэж, уг шийдвэр гаргах үйл ажиллагааны эерэг, сөрөг талыг тодорхойлох;

2. Гадаад бодлогын асуудлаар шийдвэр гаргахтай холбогдох харьцуулсан судалгааг хийж, гадаад харилцааны салбарын нэгдмэл байдлыг хангах "нэг цонхны" бодлогод нийцсэн шийдвэр гаргах механизмын талаар судалгаа, шинжилгээнд суурилсан санал дүгнэлт гаргах;

3. Олон улсын конвенц болон гадаад харилцааны салбарт хэрэглэж байгаа нэр томъёоны зөрүүтэй байдалд хяналт-шинжилгээ хийх, хэрэв нэр томъёоны зөрүүтэй асуудал байвал түүнийг жигдлэх, залруулах санал боловсруулах;

4. Ажлын хэсгийн нэгдсэн санал дүгнэлт, Байнгын хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулан Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоог
боловсронгуй болгох талаар чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Гадаад бодлогын шийдвэр гаргах тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлтийг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1.Гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох, дипломат албыг хөгжүүлэх, мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх, дипломат ажилтны эрх зүй, нийгэм, улс төрийн баталгааг сайжруулах зорилгоор Төрийн гадаад харилцааны тухай хууль, Дипломат албаны тухай хуулийн төслийг боловсруулж 2014 оны 08 дугаар сард багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2.Гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтыг хангах үүднээс Гадаад харилцааны яамны бүтцэд мэдээлэл солилцоо, төрийн гадаад үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг хариуцсан нэгж байгуулан бэхжүүлэх;

3.Гадаад харилцааны яамны мэдээлэл боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, бодлого боловсруулах чадавхыг бэхжүүлэх зорилгоор холбогдох нэгжийн орон тоо, зохион байгуулалтыг оновчтой болгох, гадаад бодлого боловсруулах, холбогдох мэдээлэл бэлтгэх үе шат бүрд тухайн нэгжийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгох;

4.Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үндсэн зорилт, тулгамдсан хэрэгцээ шаардлагыг үндэслэн Гадаад харилцааны яаманд зайлшгүй нэмэх шаардлагатай дипломат ажилтны орон тооны талаар судалгаа хийж, үе шаттайгаар шийдвэрлэх;

5.Дипломат ажилтан бэлтгэх, давтан сургах, гадаад бодлогын асуудлаар судалгаа хийх үүрэг бүхий сургалт-эрдэм шинжилгээний бие даасан байгууллагыг Гадаад харилцааны яамны дэргэд байгуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх.


Хоёр.Байнгын хорооны тогтоол хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Гадаад харилцааны сайд /Л.Болд/-д даалгасугай:

1.Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл,

танилцуулгыг Байнгын хороонд улирал тутам ирүүлж байх, Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах;

2.Тогтоолын хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг 2014 оны 11 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлэх, тогтоолын биелэлтийг 2015 оны 01 дүгээр сарын эхний хагаст багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.11 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13, Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 болон Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6 дахь заалтуудын хэрэгжилтийг шалгахыг Тусгай хяналтын дэд хороонд даалгасугай.

2. Тусгай хяналтын дэд хороонд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд ажлын хэсгийн ахлагч:

Б.Ариунсан

Тагнуулын ерөнхий газрын дарга

Гишүүд:

Т.Энхбат

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн референт

М.Бамбадорж

Улсын ерөнхий прокурорын газрын гүйцэтгэх ажилд тавих хяналт хариуцсан прокурор

Б.Мөнхбат


Харилцаа холбооны зохицуулах хорооны дэд дарга

Б.Батбаяр

Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга

3. Санал, дүгнэлт болон шийдвэрийн төслийг 2014 оны 12 дугаар сарын 01-ний дотор Тусгай хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахыг дэд ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



Ц.ОЮУНБААТАР